


БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 397↓ (сүвгаар)

УТСААР
288↓



27.5%



4.5%	18↑	БИЕЧЛЭН
7.6%	30↓	ВЭБ ХУУДАС
0.0%	0↓	ДУУТ ШУУДАН
11.6%	46↑	И-МЭЙЛ
3.8%	15↓	ЧАТ

Суваг	2024	2025
	08.20	
☎	327	288
👤	30	18
🌐	26	30
✉	27	0
✉	20	46
💬	16	15
#	445	397


Нийт дуудлага
1197↓

Хүлээн авсан дуудлага
288↓

Дуудлага авсан
26.7%↓

eMongolia-д шилжүүлсэн – 118↓
Алдсан дуудлага – 791↓

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

СБД-ийн Төв сангийн замын эсрэг талд баригдаж байгаа Бизнес Таур барилга болон урд барилга дундуур гардаг явган хүний зам дээгүүр хамгаалалт хийхгүй ажиллаж байна. Ойр орчмын аж ахуйн нэгжүүд удаа дараа хүний амь эрсдэх аюултайг сануулж шаардлага хүргүүлсэн ч хэрэгжүүлэн ажиллахгүй байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

Ерөнхий боловсролын 39-р сургууль улаан шугам татсан юм байна. Дүүгийнхээ талаар ангийн багштай нь утсаар ярихад миний дүүг “Тэнцээгүй хасагдсан тул хувийн хэргийг нь ирж аваарай” гэсэнд гомдолтой байна. Тус сургуульд өмнөх хичээлийн жилүүдэд улаан шугам гэдэг зүйл байгаагүй юм байна. 2024-2025 оны хичээлийн жилд шинээр бий болгосон. Дүүгээ үргэлжлүүлэн сургуульд нь сургах хүсэлтэй байна. Улаан шугам гэдэг зүйл боловсролын хууль журамд нийцэж байгаа эсэхийг шалгуулж, тогтоолгож, мэдээлэл авах хүсэлтэй байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

“Соргог байгаль” ХХК нь Рояал хаус констрашн ХХК-тай хамтран ХУД-23, Яармагийн урд Арцатын амны зүүн талд 178116691 дугаартай нэгж талбартай газар дээр 16 давхар 7 блок барилга барьж байгаа бөгөөд барилга барихдаа өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугамын тусгаарлах зурвасыг хаасан нь Эрчим хүчний, Газрын, Хот байгуулалтын, Барилгын, Агаарын бохирдлын тухай хуулиудыг болон MNS 4585:2016 стандартыг тус тус зөрчиж байгаа ч зөрчлийг арилгуулах төрийн байгууллагууд болон төрийн албан хаагч нар анхаарахгүй, арга хэмжээ авч ажиллахгүй байна. Иймд хуулийг хэрэгжүүлэх холбогдох төрийн байгууллага тус компанийн барьж буй барилгад хяналтыг тавьж иргэдийн зорчих газрыг чөлөөлж, барилгын үед зорчих зам гаргаж, орц гарцыг нээж, тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж өгөхийг мөн хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний хариуг албан бичгээр авах хүсэлтэй байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

191↓

Хүснэгт 1. 2025 оны 8 сарын 20-ны өдөр
Төрийн байгууллагын мэдээлэл

Хүснэгт 2. 2025 оны 8 сарын 20-ны өдөр
Төрийн байгууллагын мэдээлэл

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ: ОНЦЛОХ ГОМДОЛ

НИЙГМИЙН ДААТГАЛ

- ХУД-ийн нийгмийн даатгалын газарт гомдол гаргаж байна. 07 дугаар сард жирэмсний тэтгэмж авах хүсэлтээ өгөөд баталгаажсан боловч одоог хүртэл мөнгө нь орж ирэхгүй байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.
- СХД-ийн нийгмийн даатгалд цахимаар ажилгүйдлийн тэтгэмж олгох хүсэлтийг 06 дугаар сарын 02-ны өдөр илгээсэн. Цахим дээр хүсэлт шийдвэрлэгдсэн төлөвтэй байгаа ч ажилгүйдлийн тэтгэмж одоог хүртэл ороогүй байна. Хуваарь дээрээ 08 дугаар сарын 01 гэж тавигдсан ч ороогүй нийгмийн даатгалын газрын байцаагчаас нь тодруулахад энэ сарын 15-наас хойш орно гэсэн ч одоог хүртэл ороогүй байгаа бөгөөд утсаар залгахад огт утсаа авахгүй байна. Уг асуудлыг СХД-ийн Нийгмийн даатгалын газарт уламжилж өгнө үү.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧДЫН ХҮНД СУРТАЛ

- Би өнөөдөр БГД Спорт хорооны байранд Бичил нэг цэгийн үйлчилгээний салбарт гадаад паспорт захиалахаар очсон юм. Тэнд зөвхөн нэг ажилтан ажиллаж байна. Бусад ажилтнууд нь ээлжийн амралтаа авсан гэж тайлбарлаж байна. Ажиллаж байгаа ажилттан нь ганцаараа ажиллаж байгаа тул ачааллаа дийлэхгүй байна. Иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай авч чадахгүй дугаарласаар үдийн цайны цаг хүргэж байгаад гомдолтой байна.
- 2025.06.20-нд Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанд БНХАУ-ын иргэд хууль зөрчиж байгаа талаар нотлох баримттай гомдол гаргасан юм. Гэтэл одоог хүртэл хариу байхгүй. Хуулиа барьж ажиллахгүй байна. Асуудлыг шийдэж хариу өгнө үү.

ХАЛУУН УС

- ХУД-11, "Инэл Зайсан виллаж" хотхоны оршин суугч байна. 2024 оноос хойш хэрэглээний ус зэвтэй ирээд баллонтой ус зөөвөрлөж ашигладаг. 2025 оны 05 дугаар сараас эхлэн халуун усгүй нэлээн удлаа. Зайсан скай ХХК манайд төлбөрөө төлөөгүй гээд олгохгүй байна. Одоо 09 дүгээр сараас эхлээд халаалт өгөхгүй гээд байх юм. Энэ асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлж өгнө үү.
- СХД-20, Цэргийн хотхон 8-р байранд 05 дугаар сарын 25-ны өдрөөс хойш халуун усгүй байна. 08 дугаар сарын 31-ний өдөр ирнэ гэсэн мэдэгдэл наасан байна. Үүнээс болж оршин суугчдын эрх ашиг ихээр зөрчигдөж байна шүү дээ. Гомдлыг уламжилж өгнө үү.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

- СХД-20 хороонд шинэ сургууль баригдаад ашиглалтад орохгүй 2 жил боллоо. Сангийн шугам хоолой холбогдоогүй гэсэн шалтгаанаар хойшилсон. Энэ асуудлыг анхааралдаа авч ашиглалтад оруулах талаар холбогдох газар судлан яаралтай шийдвэрлэж өгнө үү.
- Ерөнхий боловсролын 154-р сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын танхим хүрэлцэхгүй байна гэсэн шалтгаанаар маш хол цэцэрлэгийн байранд хичээллүүлнэ гэж байна. Энэ асуудлыг эсэргүүцэж байгаа тул арга хэмжээг авч ажиллах хэрэгтэй байна. Хүсэлтийг Нийслэлийн боловсролын газарт уламжилж өгнө үү.

СУРГАЛТЫН ТӨЛБӨР, ТЭТГЭЛЭГ

- Боловсролын зээлийн сангийн зээлд би 2 жил материалаа явуулсан ба Канадын их сургуульд 40 хувийн тэтгэлэгтэй суралцдаг байхад миний хүсэлтийг хүлээн авахгүй буцаахдаа ямар шалтгаан байгааг, ямар үндэслэлээр олгохгүй байгаагаа огт хэлэхгүй юм. Зээлд хамрагдсан сурагчийн листэд ямар ч тэтгэлэггүй оюутан хүртэл байх юм. Энэ талаар мэдээлэл авах хүсэлтэй байгаа тул холбогдох газарт уламжилж өгнө үү.
- Манай хүү ерөнхийлөгчийн тэтгэлэгт Илгээлт-2023 хамрагдаад Канадын Торонто хотод суралцдаг. 2-р курсийн төлбөр хийгдэхгүй бол сургуулиасаа хасагдах дээрээ тулчихаад байна. Яагаад одоо болтол төлбөрийн асуудлыг нь шийдэхгүй байна вэ. Холбогдох газар нь уламжилж шийдвэрлэж өгнө үү.